

Эрхэм ариун амьтад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

SMC-К

Эрхэм ариун амьтад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

«Бидэнд үг хэлний шаардлага байдаггүй.
Бид чимээгүйгээр харилцдаг.
Бид эв, хайр, энх амгалангийн тухай хэлэлцдэггүй.
Бидний амьдрал угаасаа тийм юм.

~Путу



Эрхэм аруун амьтад



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай





ӨМНӨТГӨЛ

Амьтдын ертөнцөд том жижиг байхаас үл хамааран, хаа ч байдгийн нэгэн адил буяны сайн санаа л чухал билээ.

Тиймээс бяцхан хэрэм өөрийн гэсэн нэртэй байхад нугас тиймгүйг би олж мэдсэн юм.

Магадгүй энэ нь хэрэм нугасыг бодвол илүү Эрхэм Ариун Чанартайгаас (NQ = Noble Quality) тэр биз ээ.

Амьтны аливаа төрөл зүйлийн NQ нь 9% эсвэл түүнээс дээш байвал байгалиас тэд өөрийн гэсэн нэртэй байх эрхтэй байдгийг би бас мэдсэн юм. (Хүмүүс харин давуу эрхтэй байдаг.)

Зарим амьтдын NQ-г хувиар илэрхийлбэл:

Үнээ = 40%	Зарим шувуу = 30%
Заан = 30%	Халзан түнжүүлэй = 10%
Гахай = 30%	Минж = 10%
Буга = 20%	Хун шувуу = 20 %
Нохой = 30%	Галуу = 20 %
Бүргэд = 3%	Оронгутан = 20%
Хэрэм = 10%	Бар = 4%
Нугас = 8%	Арслан = 3%

Хүний хувьд:

Өндөр (90%) NQ-тэй нь цөөхөн

Доогуур (3%) NQ-тэй нь маш олон

Дундаж (10%) NQ-тэй нь мөн маш олон байдаг байна.

Амьтдын эцэг эх нь үр төлдөө нэр өгдөггүй, харин цаг нь ирэхээр тухайн зүйлийн амьтны Зөвлөлөөс нэр хайрладаг ажээ. Жишээ нь хун, галуу нас бие гүйцэхээсээ өмнө буюу бараг хоёр настайдаа нэрээ сонгодог. Харин минж болон хэрэм нэг настайдаа нэртэй болдог байна.

Зарим амьтны Эрхэм Ариун Чанар нь ижил зүйлийн амьтнаасаа илүү байх нь бий. Жишээ нь:



Эм хун Питу = 30% байхад
Эм хун Жина = 25% байна.

Зөвхөн хүмүүс бидий дунд л Эрхэм Ариун Чанарын ялгаа эрс их байдаг. Учир нь бид өөрсдийн энэрэн нигүүлсэх сэтгэлийг хөгжүүлэх илүү боломжтой; мөн бусад хүн, амьтныг асран хайрлах шаардлага бүхий нөхцөл бидэнд илүү олонтаа тулгардаг.

Тийм ээ. Үүнийг олж мэдээд би маш их гайхсан. Биет ертөнцөд хүртэл ийм гайхамшигтай зүйл олон байх юм. Эдгээрийг олж мэдэхийн тулд хүн үнэхээр л цаг зав гаргах хэрэгтэй.

Мөн өөр нэгэн зүйл бол: эмэгчин амьтад эрэгчнээ бодвол Эрхэм Ариун Чанараар нэг эсвэл хоёр хувь илүү байдаг аж. Энэ нь хүмүүсийн хувьд ч адил. Хэн нэгний эх байх нь хариу үл нэхэх хайрын сэтгэлийг улам ихээр хөгжүүлж, Эрхэм Ариун Чанарыг дадуулах тусам тэр чанар нь улам бүр нэмэгддэг бололтой.



Эдгээр зүйлсийг мэддэг болсон минь тун завшаантай хэрэг юм. Би үүнийг мэдэх гэж хичээж хайгаагүй билээ. Зэрлэг амьтадтай харьцах найрсаг холбоо маань гүнзгийрэх тусам энэ бүхэн аяндаа илэрхий болсон юм. Амьтдын заримыг нь мэддэг болмогц бусдынх нь талаарх мэдээлэл ч бас өмнө минь нээгдсэн. Миний олж мэдсэнтэй адил өчүүхэн зүйлийг л бид ойлгож мэдчихвэл амьтдад хэзээ ч урьдын адилаар хандахгүй. Бидэнтэй зэрэгцэн оршиж буй зарим амьтад, түүний дотор хэл нэвтэрч ойлголцохгүйгээсээ болж бид буруу харьцаж, бүдүүлгээр ашиглаж, үл ойшоосоор ирсэн тэр л амьтдын ертөнцийн тухай өчүүхэн мэдлэгээ энэ номоор дамжуулан хуваалцахдаа би маш их баяртай байна.

Тэдгээр амьтдын дамжуулсан бүхнийг бичсэн бол бүр олон ном болох байлаа. Тэгээд ч, өөрийнхөө тухай болон “ажлын” шаардлагаар надтай холбоотой байдаг амьтдын тухай мэдээллийг энд би оруулсангүй.

Юутай ч, бидний анд нөхөд болох амьтдын тухай их зүйлийг олж мэдээд миний сэтгэл маш их хөдөлсөн, таны сэтгэл ч бас догдолно байх гэж найдаж байна.

Хамаг амьтан амар амгалан, аз жаргалаар адислагдан хайрлагдах болтугай.

Жич: Энэ номонд орсон бүх зураг над ихэд таалагдсан, зарим зурагт нь та өөрөө тайлбар өгөөрэй. Энд өгүүлсэн үйл явдлын тухай та шимтэн уншихын зэрэгцээ тэдгээр зургийг таашаан сонирхох буй за. Энэ бүхэн нь цөм бодит орчин, болсон үйл явдал юм шүү. Зарим зурагт ховорхон тохиолдох агшинг харуулсан буй. Заримыг нь авахад олон цаг, өдөр шаардсан. Заримыг нь (дүрс бичлэг болон зураг) авахын тулд гүнзгий ус, гүн ширэнгэ туулах шаардлага ч гарч байлаа...



Талархал

Энэ бол онгон зэрлэг байгалийн тухай ном юм. Гэсэн хэдий ч би өөрөө энэ л байгалийн нэгээхэн хэсэг мэт санагдах юм. Хэдийгээр энэ ном миний тухай биш ч гэлээ, зарим хэсэгт нь миний зураг бий. Та нарт таалагдана гэж найдаж байна. Та бүхэнд зориулж, зургийг минь авч өгсөн туслахууд:

Томас Лернин

Т. Жүн

Жас Си

Т. Хао

Стив Андресс

Т. Хай нартаа баярлалаа



Бусад зураг болон байгалийн үзэсгэлэнт ахуйг та бүхэн настай эмэгтэй надгүйгээр олж харна. Гэхдээ би зургийн аппаратныхаа ард та нартай үргэлж хамт байх болно.

Энэ номонд ороогүй бусад оршин суугчид ба жуулчид: том загас, мэлхий, яст мэлхий, туулай, шар шувуу, тагтаа, бусад олон төрлийн шувууд, хүрэлзгэнэ, эмгэн хумс, буга зэрэг амьтад бас бий шүү. Энэ номыг та бүхэнд хүргэхэд тэдний үзүүлсэн хайр, өгөөмөр дэмжлэгт би бас талархаж байна.

Амьтдын зургийг авах, бичих ажлыг би үргэлж хийсэн ч чадахаар санагдсан. Тэд цөм ийм бишрэм гайхалтай болохоор тэгж болохгүй зүйл юу байх билээ. Жишээ болгон өгүүлэхэд: намайг ойролцоо нь буусан үед мэлхийнүүд шөнийн турш, үүр цайтал, зарим үед бүр түүнээс ч удаан хоорондоо харилцан дуулцгаадаг байв. Энэ нь яг л төгс найруулсан, зогсолтгүй үргэлжлэх үнэ төлбөргүй хөгжмийн тоглолт мэт байдаг. Хэн тэдэнд тийм гайхалтай хоолой, эрч хүчийг өгдөг байна аа? Ийм бяцхан биенд шүү.

Нөгөөтэйгүүр би таныг төсөөлөн бодох чадвараа сэргээхэд дэм болж магадгүй. Эс бөгөөс та өөрөө тэдний зургийг дарж үзээрэй.

Дурлан бичсэн энэ номондоо би хайртай

Дурдсан болоод бусад бүх л амьтанд бас хайртай

Сонгож зургийг нь авсан энэ нутагт би хайртай

Сонирхон таашааж та уншина гэхээс сэтгэлдээ баяртай

Жина Морүвэй
Питу Сай Сай
нарыгаа зүрхний угаас хайрлан,
энэхүү номыг онцлон тэдэнд зориулав.



Та нарынхаа хайр энэрэл, тус дэмэнд баярлалаа. Амин хайртай нутагтаа нэвтрүүлэн, зургаа авахуулж, та нарын тухай ном бичихийг над зөвшөөрсөнд тань талархаж байна.

*Анд нөхөр минь болохоор,
Ажил үйлсэд минь туслахаар алсын алсаас
Алдрай та нар минь ирсэн.
Халуун элгэмсэг хайр,
Хамгийн нандин ухаарлыг тань...*

*Энэ дэлхийн хүмүүс ойлгодог ч болоосой
Эрхэм оршихуйгаас тань цацрах
Эргэн тойрноос тань ундрах хайрыг мэдэрдэг ч болоосой
Эндээс та нар явлаа ч
Эсвэл үлдэж (мэдээж тэгвэл сайхан) суурьшлаа ч
Дэргэд минь байсан баяртай мөчүүдийг
Дандаа нандигнаж явна би*

Эдгээр тосгонд болон ойр орчимд нь оршин буй бүхэнд

*Зулзаган илнүүддээ өгөх талхны төлөө хашаа даван харайсан буга,
Өөрт нь амттан авчирсан ч авчраагүй ч үргэлж намайг
угтан мэндэлж уянгалан янцгаадаг хөрш морь,
Өчүүхэн дэгдээхэйнүүдээ хамгаалахын тулд юутай ч тулахад бэлэн
өрх толгойлсон ээж нугас,
Зураг авахуулахаасаа дэндүү ичдэг туулай
Нялх үрсээ тэжээх талх авах гэж надаас гэрэвших айдсаа давж
(хажууд ирдэг) зоригт халзан түнжүүлэй*

*Хавь ойрынхоо хэнтэй ч хүнс хоолоо хэзээд хуваалцдаг цахлайнууд
Уянгалаг найрал хөгжмийн адил хэмнэл айзмаар хүчүрнэлдэгч
мэлхийнүүд*

*Над итгэж буй нь илтхэн харагдах минжнүүд
Амь эрсдэхээс айлгүй ангаахай үрсээ хамгаалдаг зоригт галуунууд
Баяр хөөр, дуу хөгжим над бэлэглэдэг бүх шувууд
Миний цэцэрлэгт зугаалан хөлхөх яст мэлхийнүүд
Мод чулуу, зэрлэг ургамал, газар шороо, цэцэгс гээд
Энд тэндгүй, хаа сайгүй орших та бүхэнд
хайр талархал бүхнээ зориулъя.*

Та нэг бүрийн дотоодод орших энэрлийн ундаргаас, дэргэд чинь би зөвхөн хайрыг л мэдэрдэг.



Эцэст нь, далайн чанадад дияан удирдан явах зуурт минь хорвоог орхин одсон хунгийн бяцхан дэгдээхэйн дурсгалд энэхүү номоо бас зориулъя.

Эргэж ирээд: “Чамайг би их санасан шүү” гэж хэлэх боломж олдсон ч болоосой. Эгч ах нар шигээ өсч том болохыг чинь харсан ч болоосой. Хажууд чинь байж хамгаалж чадаагүйдээ сэтгэл минь гансарч, уй гунигт автана.

Диваажинд чамд илүү сайхан байгааг мэдэж байгаа хэдий ч, би үл тоох хүйтэн сэтгэл гаргаж нэг л чадахгүй нь.

Амьдралын хатуу ширүүнд арай л дэндүү эмзэгхэн байсан эгдүүтэй бяцхан дэгдээхэй минь чамд энэ ном бас зориулагдсан юм шүү.

*Эрх дураараа дүцлэн нисэх хүртэл чинь
тэжээн торниулах байсан юмсан.*

Энхрийлэн чамайг тэврэх дуртай л байх байсан

Ингэж харин чадахгүй байсныг минь чи мэднэ.

Илбэж торгомсог өдийг чинь таалахад сайхан л байх байлаа

Ингэж харин зүрхлэхгүй байсныг минь чи мэднэ

Зэрлэг онгон авир занг чинь хүндэлдэг учраас тэр

Хариу нэхээгүй ариун холбоогоо хайрладаг учраас тэр.

Эцэг эхийн чинь адилаар чамайг би хайрлахыг хүсч байсан:
Чамайг асран хамгаалж байгаад, цаг нь ирэхээр явуулах байсан юм.
Гэвч ийм эрт, эмзэгхэн балчир насанд чинь явуулах гээгүй. Диваажинд
төлөвлөгөө байдгийг, бас тэнд чамайг “зохих ёс” -оор нь угтаж авсан
гэдгийг би ойлгож байна л даа. Гэхдээ өөрийнхөө нялх үрийг алдсан
мэт чамайг би үгүйлсэн хэвээр. Чи минь юутай бяцхан, юутай эмзэгхэн
байсан билээ; бүр нэрээ ч авч амжаагүй нялх байсан шүү дээ...

Хагацъя даа хонгорхон минь, чамд хэчнээн их хайртайг минь чи
дээрээс хараад мэдэж байгаа. Чиний тухай одоо ингээд бичиж суухад
нулимс минь урсаж буйг харж байна уу, эмзэгхэн энхрий минь ээ?

Чамайг би “Хайрын Гүнж” хэмээн дурсана

Чи тэр л юм шүү дээ


Амьтад та нар бүгд л Хайр юм шүү дээ

Сэтгэлийнхээ гүнд та нарыг би хайрладаг

Хэр гүн болохыг зөвхөн би өөрөө л мэдэх юм даа

Их Багш Чин Хай






Байгаль дахь Бурханы бүтээлүүдийн өнгө тунамал хөргөөр чимэглэгдсэн, Эрхэм ариун амьтад хэмээх энэ номын үгс амгалан өнгө аяст айзам хэмнэлээр хөвөрнө. Тийн эргэх номын хуудсууд онгон байгалийн хайр хүрэм төрөлтний баясан зочилдог газар болох нэгэн “хатагтай”-н гэр Аморад таныг хүргэх болно.

Тэр “хатагтай” болбоос Их Багш Чин Хайгаас өөр хэн байх билээ. Харин Эрхэм ариун амьтад хэмээх энэ ном бол энгийн хэрнээ сэтгэлийн нандин чавхдас хөндсөн, Түүний бас нэгэн бэлэг юм. Багшийн өөрөө бичиж, зургийг нь авч, эмхэтгэсэн энэ үнэт эрдэнийн ном бидэнд хосгүй үзэсгэлэнт ертөнцийн үүдийг нээн өгч байна. Цэлмэг хөх тэнгэрийн доор бидэнтэй зэрэгцэн орших хун, галуу, хэрэм, минж, тэр ч бүү хэл цэцэрлэгийн бяцхан эмгэн хумс хүртэл үнэнч сэтгэл, уужим ариун санаатай болохыг уншигч та шууд мэдэрнэ. Хэдийгээр хүмүүсээс ичдэг ч эдгээр амьтад зургаа татуулахыг зөвшөөрч, Хатагтайн халамжлан дайлдаг амтат хоол уруу үнэхээр дуртайяа яаран очихыг харна. Энэхүү номоор илгээж буй хайр нь юутай ч зүйрлэшгүй - эрхэм дээд чанар, адилслалаар дүүрэн болоод мөнх оршихуйн адил цаглашгүй билээ.

Элгэмсэг уншигч таныг Эрхэм ариун амьтад номынхоо хуудас бүрийг шимтэн унших болтугай хэмээн хүсэн ерөөе. Эцэст нь, байгаль дэлхийн гоо үзэсгэлэн болоод оршин амьдрагсдынх нь хамгийн эрхэм нандин чанарыг хайрлан хүндлэхийн учир утгыг харуулж өгсөн хайрт Багшдаа гүн талархлаа илэрхийлье.

Номын баг эмхтгэв



Уг номыг бүтээх явцад өөрсдийн хичээл зүтгэл, хайраа зориулсан хүмүүс:

Ев Лин, Ким Жон Юн, Надир Ен, Жекки, Кюүтийз, Пөрль Хуан, Анни Юү, Б.Сэлэнгэ (дизайнер бас эмхэтгэсэн)

Ев Лин, Надир Ен, Гари Лай, Ван Бор Танг, Юү Хуй Чун (график дизайн)

Жейн Чу, Линн Макжи, Грейс Чен, Сун Ван (хянагч), Б.Мөнх-Эрдэнэ, М.Мишээл, Б.Намуун, Д.Алтанзаяа (орчуулагч), С.Галсан, Ж.Чойнхор, Л.Төмөрбаатар, Хүрэлбаатар (орчуулгыг хянан тохиолдуулсан), О.Пагамжав (хэвлэлийн эхийг хянасан) нарт

Их Багш чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна.

Их Багш Чин Хайн товч намтар

Их Багш Чин Хай төв Ау Лакт төрсөн (Вьетнам). Арван найман насандаа Их Багш Чин Хай Англи руу сурахаар зорьсон бөгөөд Франц уруу, дараа нь Герман уруу очиж тэндээ Улаан Загалмайд ажиллаж байхдаа Герман эмчтэй гэрлэжээ. Аз жаргалтай гэрлэлтийн хоёр жилийн дараа түүний нөхрийн адис зөвшөөрлөөр төгс гэгээрлийн замыг сонгохын тулд гэр бүлийн харилцаагаа цуцалж улмаар хүүхэд ахуйн насны хүсэл мөрөөдлөө биелүүлсэн. Үүгээр түүний олон улс орноор хийх хүнд бэрх аялал эхэлсэн бөгөөд Гималайд төгс гэгээрсэн багштай уулзсанаар түүний эрэл дуусжээ. Их Багш Чин Хай тэнгэрлэг дотоодын гэрэл аялгууны бясалгах аргыг уламжлан авч түүнийгээ Гуань Инь гэж нэрлэв. Хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст төгс гэгээрэлд хүрсэн.

Үнэнийг эрэлхийлэгчдийн чин хүслийг биелүүлэхийн тулд Их Багш Чин Хай бүх улс үндэстний болон олон янзын гарал үүсэл, шашин шүтлэгтэй хүмүүст Гуань Инь баясалгалын аргыг заадаг. Түүний хайр болон амар амгалангийн илгээмж дэлхий даяарх хүмүүст оюунлагийн эрх чөлөө, итгэл найдварыг бэлэглэхийн хамт бүгдэд Үнэн Ёс, Буян, Амьдралын Гоо Үзэсгэлэнг сануулдаг.